



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/221

Булган сум

“Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох”
үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, 30.1.10, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/200 дугаар тушаалын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Боловсролын газрын дарга
Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого хариуцсан мэргэжилтэн
Насан туршийн суралцахуйн төвийн багш
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн хөгжил оролцооны асуудал хариуцсан мэргэжилтэн
Хөдөө аж ахуйн Их сургуулийн харьяа Булган Политехникийн коллежийн Нийгмийн түншлэл, үйлдвэр сургалтын арга зүйч
Нарийн бичгийн дарга: Боловсролын газрын Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын асуудал хариуцсан ахлах арга зүйч

2. “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргад даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 02-ны А/59 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР